

“ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ” ХК-ийн ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ПРОТОКОЛ

2021 оны 4-р сарын 24-ний өдөр

“Дархан гурил тэжээл” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2020 оны 4-р сарын 24-ний өдрийн 12.00 цагт ZOOM цахим хурлын программаар эхлэв.

Хурлын даргаар томилогдсон Ш.Энхтөр хурлыг удирдан явуулав.

Хурлын дарга Ш.Энхтөр тооллогын комиссын бүрэлдхүүн Д.Мөнхцэцэг, Л.Энхтайван нарыг танилцуулж, тооллогын комиссын даргаар томилогдсон Б.Баасандоржийг хурлын ирцийн талаар мэдээлэл хийхийг хүслээ.

Б.Баасандорж: Хуралд нийт 614,603 ширхэг хувьцааг эзэмшигчдээс 341,408 ширхэг хувьцааг эзэмшигчид буюу нийт хувьцааны 55,55%-ийг эзэмшигчид ирсэн байна.

Хурлын дарга Ш.Энхтөр: Компанийн тухай хуулийн 69.1 болон “Дархан гурил тэжээл” ХК-ийн дүрмийн 5.21-д зааснаар ирц хүчин төгөлдөр тул хурлыг хуралдуулахаар шийдвэрлэв.

Хурлын дарга Ш.Энхтөр: Ээлжит хурлын хэлэлцэх асуудлуудыг танилцуулав.

1. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
2. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
3. Зохион байгуулалтын асуудлууд байгаа.

Оролцогчдын 100% саналаар хэлэлцэх асуудлыг батлав.

Хурлын дарга Ш.Энхтөр: Хурлын дэгийг уншиж танилцуулав. /дэг хавсаргасан/ Хурлын дэгийг 100% санал нэгтэй батлав.

Хурлын дарга Ш.Энхтөр: Хэлэлцэх асуудалдаа оръё. Эхний асуудал “Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт”-ийг хэлэлцэж батлах асуудал байгаа. Гүйцэтгэх захирал Б.Түвшинтөр танилцуулна.

Гүйцэтгэх захирал Б.Түвшинтөр “Дархан гурил тэжээл” ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлт”-ийг танилцуулав.

Дүгнэлтийг хавсаргалаа.

Хурлын дарга Ш.Энхтөр: Дүгнэлттэй холбоотой асуулт, санал байна уу?

С.Намсрайжав: Хэлэлцэх асуудлаа бүгдийг сонсож танилцчихаад санал, асуултаа нэгтгэж тавих саналтай байна.

Хуралд оролцогцогсод 100% дэмжлээ.

Хурлын дарга Ш.Энхтөр: дараагийн асуудал нь компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал байгаа. Хурал даргалагч Ш.Энхтөр миний бие танилцуулна.

Танилцуулгыг хавсаргалаа.

Хурлын дарга Ш.Энхтөр: Дараагийн асуудал бол ТУЗ-ийн ердийн гишүүн С.Намсрайжав, хараат бус гишүүн С.Буянхишиг нар өөрийн хүсэлтээр ТУЗ-ийн бүрэн эрхээс татгалзах өргөдөл өгсөн байна. Ийнхүү ТУЗ-ийн гишүүний сул орон тоонд С.Энхтайван ердийн гишүүнд, Н.Ариунтунгалаг нар нэр дэвшиж байгаа тул тэдгээрийг сонгох эсэхэд санал хураах, мөн ТУЗ-ийн гишүүдийн улируулан сонгох тухай асуудлыг хэлэлцэнэ. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдэд нэр дэвшигчдийн анкетийг танилцуулав.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлуудыг сонсож танилцлаа. Асуулт, саналдаа орьё.

Асуулт, санал байна уу? Байхгүй байна.

Та бүхэнд хурлын хэлэлцсэн асуудал бүхий саналын хуудас өгсөн байгаа. Саналаа өгнө үү.

Тооллогын комиссын дарга Б.Баасандорж саналын хуудсуудыг нэгтгээд тогтоолоо танилцуулна.

Б.Баасандорж тооллогын комиссын тогтоолуудыг танилцууллаа.

Хурлын дарга Ш.Энхтөр: Хэлэлцсэн асуудлыг дүгнэж хурлын тогтоолын төслүүдийг танилцууллаа.

Хуралд оролцогсод 100%-ийн саналаар батлав.

Хурлын дарга Ш.Энхтөр: Дархан гурил тэжээл ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдаж төлөвлөсөн асуудлуудаа хэлэлцэж холбогдох шийдвэрүүдийг гаргалаа. Хурлын материалаа Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн бирж, Улсын бүртгэлийн албанд гаргаж, бүртгүүлэх ажлыг ТУЗ, гүйцэтгэх удирдлагад даалгаж байна. Хуралд оролцсон та бүхэнд талархал илэрхийлж, ажлын амжилт хүсье.

Хурал 2020 оны 4-р сарын 30-ны 14.00 цагт өндөрлөв.

Хурлын дарга

Хурлын тэмдэглэл хөтөлсөн

Ш.Энхтөр
С.Намсрайжав

